



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 01

Эрдэнэбулган сум

Дархлаажуулалтын үйл ажиллагааны
аюулгүй байдал, бүртгэл, мэдээллийг сайжруулах тухай

Дархлаажуулалтын тухай хууль, дархлаажуулалтын чиглэлээр хэрэгжиж байгаа эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилт, дархлаажуулалтын үйл ажиллагааны аюулгүй байдал, бүртгэл, мэдээллийг сайжруулах зорилгоор Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга, вакциначууруудад дараах албан даалгаврыг хүргүүлж байна.

Үүнд:

1. Сар бүрийн 15-25-ны хооронд дараа сарын нөөцөө зөвхөн вакциначуурууд өөрийн биеэр ирж, вакцины нэр, хаяг, хугацааг шалгаж авах /өөр хүнд вакциныг өгөхгүй/
2. Эрүүл мэндийн газрын вакцины агуулахаас вакцин авахаар ирэхдээ вакцин зөөврийн саванд хэм хяналтын хэрэгсэл болон мөсөн элементийг тогтмол хийж ирэх
3. Эрүүл мэндийн газрын вакцины агуулахаас эрүүл мэндийн төв дээрээ вакциныг авчрах үеийн хэмийг тогтмол шалгаж, тэмдэглэх. Хэм алдагдсан бол Эрүүл мэндийн газрын дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж, шийдвэрлүүлэх
4. Вакциначууруудыг эзэнгүй үед бусад орлон ажиллах ажилтнууд вакцин андуурагдаж хийхээс сэргийлж, вакциныг хөргөгчинд хадгалахдаа нэр, хаягийг тодорхой бичиж, төрөлжүүлж хадгалах.
5. Вакциначуурыг орлон ажиллах ажилтныг вакциначуурууд сувилагчийг дагалдуулан зааж сургасан байх
6. Вакцин хадгалах хөргөгчний аюулгүй ажиллагаа, хэмийн тогтвортой байдалд тогтмол хяналт тавьж ажиллах
7. Вакцин авахаар ирэхдээ өмнөх сарын вакцины мэдээг цаасаар гарган ирж сар бүр тулгалт хийж, зөрүүг тухай бүр засч хэвших
8. Вакцин биобэлдмэлийг тарихдаа хүчинтэй хугацаа, ампул флакон цуурч хагарсан, шошго унасан эсвэл уншигдахгүй болсон, өнгө өөрчлөгдсөн, тунадас үүссэн, халуун хүйтний нөлөөллөөр гэмтсэн, тээвэрлэлтийн явцад хөлдсөн эсэхийг тогтмол шалгаж, тарилга хийх стандартын дагуу тарих /Нэр, сери, хугацааг 3 удаа баталгаажуулан унших, тарих талбайг зөв сонгож, зөв халдваргүйтгэж тарих/
9. Вакцинд хамрагдахын өмнөх үзлэгийг хийсэн эмч нар үзлэг хийсэн мэдээллээ үзсэн даруйдаа цахим программд оруулах
10. Вакциначуурууд вакциныг тарьсан даруйд цахим программд мэдээллийг оруулах

11. Олон хүн тунтай вакциныг задалсан он, сар, өдөр, цаг минутыг тухай бүр тэмдэглэж, хугацааг мөрдөж тарих


12. Вакцинжуулалтын үйл ажиллагаатай холбоотой бүх анхан шатны бичиг баримтыг тухай бүр нь өдөр тутам, бүрэн, зөв хөтөлж хэвших

13. Вакцин биобэлдмэлийн сарын мэдээг сар бүрийн ажлын сүүлийн өдрийн 16.00 цагаар тасалбар болгон цахимаар хугацаанд нь мэдээлж хэвших

14. Вакцинд 2016 оноос эхлэн хамрагдсан хүүхдүүдийн мэдээллийг цахим программд нөхөж оруулах үйл ажиллагаа хангалтгүй байгаа тул 2016-2021 онд вакцинд хамрагдсан хүүхдүүдийн мэдээллийг ehealth.gov.mn программд, 2022 оноос хойш вакцинд хамрагдсан хүүхдүүдийн мэдээллийг ehospital.mn программд 2023 оны 3 дугаар сарын 30-ны дотор багтаан бүрэн оруулах

15. Товлолын дархлаажуулалтанд хамрагдвал зохих хүүхдүүдийг 99.0 хувиас дээш хамруулж, дархлаажуулалттай халдварт өвчнөөс сэргийлэх. 2022 онд дархлаажуулалтын хамралт 98 хувиас доош байсан Ихтамир, Тариат, Өндөр-Улаан, Жаргалант, Цэцэрлэг, Батцэнгэл, Өлзийт сумын эрүүл мэндийн төвүүд дархлаажуулалтыг хамрагдалтыг нэмэгдүүлэх

ДАРГА



Р.ГАНДИЙМАА